

Хангайн бүсийн торол бүрийн малын ашиг шимийг бага боловч нэмэгдүүлэх, хүйтний улиралд тэдгээрийн амьд жингийн бууралтыг багасгах, улмаар малчин олны тогтвортой амьжиргааг сайжруулах үүднээс Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо эрдсийн шахмал тэжээлийн цехийг Архангай аймгийн Ихтамир суманд байгуулж, малчдад зориулан вйлдвэрлэл вйлчилгээ явуулах ажлыг эхлүүлээд байна. Энэ вйлдвэрийг байгуулахад Ихтамир сумын БАХ-ийн малчид хандив оруулжээ.

Ихтамир суманд вйлдвэрлэж буй эрдсийн шахмал тэжээлийн давуу тал

- Хангайн нурууны бүс нутагт байдаггүй буюу маш ховор эрдсээр баяжуулсан.
- Малд огдог уламжлалт хужир, шүү, давсыг бодвол энэхүү шахмал тэжээл нь салхи, цас, бороо, малын холд тодийлон үрэгддэггүй.
- Энэхүү эрдсийн шахмал тэжээлийг хэрэглэснээр нутгийн үхэр, сарлагийн үнээний сүүний гарцыг 15-20 хувь, амьд жинг мон хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой богоод аль ч торлийн малын намрын амьд жингийн бууралт овол, хаврын улиралд 10-аас доошгүй хувиар багасдаг нь туршлагаар нотлогдсон.

Тус вйлдвэр ажлын 100 одорт 60-70 тонн тэжээд вйлдвэрлэх хүчин чадалтай.

Туршилтын дүнгээс харахад хургатай хонь хяналтын хэсгээсээ 9.2 хувиар илүү таргалж, ноосны гарц 16.8 хувь дээшилсэн тодийгүй хурганы амьд жин 13.5 хувиар давуу болсон байна.

Манай малчид давс, хужир, шүүг мал сүрэг, ахуйдаа хэрэглэж ирсэн уламжлалтай. Эрдэс тэжээл элбэгтэй нутгийн мал осголвон, овол, хаврын улиралд амьд жингээ бага алдаж онд мэнд ордог, урин дулааны улиралд тарга хүчээ илүү авдаг онцлогтой. Иймээс малчид хужир, шүү мал таргалуулахад ташуур, турахад тушаа хэмээн үзэж иржээ.

Эрдэмтдийн судалж тогтоосноор малын биед 11 торлийн үлэмж язгуур махбод (макроэлемент), 65 торлийн бичил язгуур махбод (микроэлемент) биологийн чухал үүрэгтэй оролцдог богоод эдгээр эрдэс бодис эс, эд, эрхтэнд нэг талаар тодорхой тун хэмжээтэй агуулагдаж, ногоо талаар хоорондоо нарийн харилцаатай хам вйлчилдэг ажээ. Зайлшгүй хэрэгцээт үлэмж ба бичил язгуур махбодын аль нэг нь дутах юмуу илүүдвэл амьтны бодисын солилцоо хямарч осолт хогжилт, ашиг шим нь саарч улмаар эмгэг үүсгэдэг аж. Мал сүрэг дээрх олон янзын химийн бодисын заримыг нь ус, бэлчээрийн ургамал, зүйл зүйлийн тэжээлээс, ногоо хэсгийг нь байгалийн давс, хужир, шүүнээс авч хэрэглэдэг байна. Хужирт нүүрсхүчлийн натрийн давс, шүүнд хүхэр хүчлийн натрийн давс, давсанд хлорт натри баялаг бол бусад олон эрдэс огт байдаггүй буюу байгаа нь торлийн хувьд цоон, тун хэмжээгээр бага аж.

